



"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧНЫ  
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН  
НЭРЭМЖИТ ТӨГӨЛ БАЙГУУЛАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд  
байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн  
захиргааны төв байгууллагын нэрэмжит төгөл  
байгуулах

Тендер шалгаруулалтын дугаар:

ОИГ/20240201032

Улаанбаатар хот  
2024 он

# ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

САНАМЖ .....	3
I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	3
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	10
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	19
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	27
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	31

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

<b>1. Тендерийн цар хүрээ</b>	1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил (цаашид “ажил” гэх) гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.				
<b>2. Санхүүжилтийн үүсвэр</b>	2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.				
<b>3. Худалдан авах ажиллагааны тогтоомж</b>	3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.	3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.	3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 <sup>1</sup> , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.		
<b>4. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага</b>	4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.	4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр хуульд заасан ерөнхий шаардлага хангасан байна.	4.3. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.	4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.	4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
<b>5. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага</b>	5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгүүлэх мэдээллийг гэрээнд заасан байна.	5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.	5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.		
<b>6. Худалдан авах ажиллагааны систем</b>	6.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем				

([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

**7.Тендер шалгаруулалтын баримт бичиг**

**8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн тодруулах**

**9.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

**10.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

**11.Тендер шалгаруулалтын хэл**

**Б.АГУУЛГА**

7.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;

V Бүлэг. Гэрээний нөхцөл

7.2.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

8.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

8.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

8.3.Тодруулга авах хүсэлтийг үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

8.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

8.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 9-д заасныг мөрднө.

9.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

9.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

10.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

10.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

**В.Тендер бэлтгэх**

11.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг,

		мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
		11.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
		11.3.Хэрэв ТШЗ-ны 11.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.
		11.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
<b>12.Тендерийн бүрдэл</b>	<b>иж</b>	<p>12.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>12.1.1.TШЗ-ны 13-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</li> <li>12.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</li> <li>12.1.3.TШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</li> <li>12.1.4.TШЗ-ны 15-д зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</li> <li>12.1.5.TШЗ-ны 16, 17, 18-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</li> <li>12.1.6.TШЗ-ны 19-д заасны дагуу техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу ажил гүйцэтгэхийг нотлох баримт бичиг;</li> <li>12.1.7.TШЗ-ны 22.4-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</li> </ul> <p>12.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p>
<b>13.Тендерийн жишиг маягт</b>		13.1.Оролцогч IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
<b>14.Хувилбарт санал</b>		14.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.
<b>15.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг</b>		<p>15.1.IV бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэсэн хуулийн 7.2-т заасан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>15.2.TШЗ-ны 4.1, 15.1-д заасан маягтыг магадлахтай холбоотой ирүүлэх баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>15.3.Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх ба нотлох баримт бичиг ирүүлнэ.</p>
<b>16.Чадавхын болон туршлагын шаардлага</b>		<p>16.1.Захиалагч ТШЗ-ны 17, 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.</p> <p>16.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.</p>

	16.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 17, 18-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
	16.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 17, 18-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
<b>17.Санхүүгийн чадавхын шаардлага</b>	17.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
	17.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
	17.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
	17.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшихи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгуулагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>18.Техникийн болон туршлагын шаардлага</b>	18.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
	18.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
	18.3.Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
	18.4.ТШЗ-ны 18.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
<b>19.Ажлыг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэхийг нотлох баримт</b>	19.1.Оролцогч үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон эцсийн үнээр захиалагчийн баталсан техникийн тодорхойлолт, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэх тухай мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ.
<b>20.Тендерийн үнэ</b>	20.1.Үнийн санал ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.
	20.2.Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нэхцэлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
	20.3.Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

<b>21.Тендерийн валют</b>	21.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
<b>22.Тендерийн үнэ</b>	<p>22.1.Унийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.</p> <p>22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>22.3.Унийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.4.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
<b>23.Тендер хүчинтэй байх хугацаа</b>	<p>23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.</p> <p>23.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>23.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэх ба ТШЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.</p>
<b>24.Тендерийн баталгаа</b>	<p>24.1.Хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>24.2.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.</p>
	<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>
<b>25.Тендер баталгаажуулах, илгээх</b>	<p>25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ-ны 24-т зааснаар илгээнэ.</p> <p>25.3.Оролцогчиг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.4.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p>

25.5.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй.

25.6.Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа** 26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

#### **Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА**

**27.Үнийн санал дуудах хугацаа** 27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дараа эхэлнэ.

27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.

27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.

**28.Тендер нээх** 28.1.ТШЗ-ны 27.3-т заасан хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.

#### **Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

**29.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх** 29.1.Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 12-т заасан тендерийн бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.

29.2.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмблэгдсэн тендерийг хянан үзнэ.

**30.Тендерийн талаар тодруулга авах** 30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.

#### **Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

**31.Мэдэгдэл хүргүүлэх** 31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**32.Гүйцэтгэлийн баталгаа** 32.1.Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

32.2.Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**33.Урьдчилгаа төлбөр** 33.1.Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг өгөгдлийн хүснэгтэд заана.

33.2.Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 33.1-д заасан

үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.

**34.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

34.1.Захиалагч ТШЗ-ны 7.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

34.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

34.3.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 34.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ.

34.4.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

**Ж.БУСАД**

**35.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах**

35.1.Захиалагч ТШЗ-ны 29.2-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг ТШЗ 31.1-д заасан шийдвэрт заана.

35.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.

**36.Тендер шалгаруулалтад гомдол гаргах**

36.1.Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-НЫ

ХОЛБОГОДО

Х ЗААЛТ

ТШЗ 1.1

ТШЗ 1.1

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Захиалагчийн нэр: **Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар**

Зарлалын дугаар: **ОИГ/20240201032**

Тендер шалгаруулалтын нэр: "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрэмжит төгөл байгуулах

Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: **багцгүй**

ТШЗ 2.1

Санхүүжилтийн эх үүсвэр: **Улсын төсвийн хөрөнгө**

Нийт төсөвт өртөг: **100,000,000.00 (зуун сая төгрөг)**

### Б.АГУУЛГА

ТШЗ 8.1

Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:

Хариуцсан ажилтан: **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ "ОЙН ГАЗАР"**

Хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХЭЛТЭС, 301 ТООТ**

Утасны дугаар: **7711-1180**

Цахим шуудан: [info@forestry.gov.mn](mailto:info@forestry.gov.mn)

ТШЗ 10.1

Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: **"ҮГҮЙ"**

### В.ТЕНДЕР БЭЛТГЭХ

ТШЗ 11.2

Тендер шалгаруулалтын хэл: **Монгол хэл**

ТШЗ 14.1

Хувилбарт санал ирүүлэхийг: **"ЗӨВШӨӨРӨХГҮЙ"**

ТШЗ 15.2

Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: **"ШААРДАНА"**

1. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСНААС ХОЙШ ХУГАЦААНД ЦАХИМ СИСТЕМЭЭС АВСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН БОЛОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТЫГ ЦАХИМ СИСТЕМИЙН ХОЛБОГОДОХ ТАЛБАРААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ ТУС ТУС ИРҮҮЛНЭ.
2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРЭЭР ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ӨР, ТӨЛБӨРГҮЙ ТАЛААРХ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЛАВЛАГААГ ЦАХИМ СИСТЕМЭЭС АВЧ, ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ ЦАХИМ СИСТЕМЭЭР ХОЛБОГОДОХ ТАЛБАРААР ИРҮҮЛНЭ.
3. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭТГЭЭДИЙН ИТГЭМЖЛЭЛ ИРҮҮЛНЭ.
4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ТОДОРХОЙЛОЛТ, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ИРҮҮЛНЭ.

- Тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэзвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагaa авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагaa цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг
- цахим хэлбэрээр ирүүлнэ.
- Жич: Дээр 2 лавлагaa авах зааварчилгаатай [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.

- 5. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨЛТИЙГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ (E-MONGOLIA) СИСТЕМЭЭС ШАЛГАНА.**
- 6. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГҮҮЛСЭН ГАЗАР, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХЯАГИЙГ ТОДОРХОЙЛСОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХЭЭС ХИЙСЭН ХУУЛБАР, ЭСВЭЛ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ БУСАД БАРИМТ БИЧИГ**

Туслан гүйцэтгэгч, түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “ШААРДАНА”

- ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТУС БҮР ЕРӨНХИЙ ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙХ БӨГӨӨД ХОЛБОГОДХ МЭДЭГДЭЛ, БАРИМТ БИЧИЙГ ЭНЭ ХУУЛИЙН 7.2, 7.3-Т ЗААСНААР ИРҮҮЛНЭ.
- ТЕНДЕРТ ИРҮҮЛЭХ ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ НЬ ХУУЛИЙН 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙНА. САНГИЙН САЙДЫН 2023 ОНЫ А/248 ДУГААР ТУШААЛААР БАТЛАГДСАН “ЦАХИМ СИСТЕМЭЭР ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЖУРАМ”-ЫН 2.3.1-Д ЗААСНААР ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭГ ЦАХИМ СИСТЕМЭЭР БАТАЛГААЖУУЛСАН БАЙНА. МӨН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ХУВИЙГ ТЕНДЕРИЙН ХАМТ ИРҮҮЛЭХ.
- ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭНД ТҮНШЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮН БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮД ТУС БҮРИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮНИЙН ДҮН, ХУВИЙГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙНА.
- ТҮНШЛЭЛИЙН АЛЬ НЭГ БОЛОН БҮХ ГИШҮҮНИЙ НЭРИЙН ӨМНӨӨС ҮҮРЭГ ХҮЛЭЭХ, ЗААВАРЧИЛГАА ХҮЛЭЭН АВАХ, ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХЭД ТЭДГЭЭРИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ НЭГ ГИШҮҮН ТОМИЛОХ.
- НИЙТ ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ДОТОР ТӨЛБӨРИЙГ ЗӨВХӨН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮНТЭЙ ТООЦОХЫГ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГЭР ЗОХИЦУУЛСАН БАЙХ.
- ТҮНШЛЭЛИЙН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ГИШҮҮН ТШЗ-НЫ 18, 19-Д ЧАДАВХЫН БОЛОН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН 40-ААС ДЭЭШ ХУВИЙГ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТУС БҮР 25 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИЙГ ХАНГАСАН БАЙНА. ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛООГҮЙ БОЛ ЕРӨНХИЙ ШААРДЛАГАД НИЙЦЭХГҮЙ ГЭЖ ҮЗНЭ.

Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 20 хүртэл хувь байна. Туслан гүйцэтгэгчтэй холбоотойгоор дараах материалыг ирүүлэх шаардлагатай.

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ ЦАХИМ СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН БАЙНА. ГЭРЭЭНД ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ, ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮН, ХУГАЦААГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙНА. ТУСЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ ХУУЛИЙН 6.4-Т ЗААСНЫГ ЗӨРЧСӨН БОЛ ЗАХИАЛАГЧ ТУХАЙН ТУСЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ, ТУСЛАН

ГҮЙЦЭТГЭГЧИД ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙГ ТЕНДЕР ХЯНАН УЗЭХЭД ХАРГАЛЗАН УЗЭХГҮЙ.

- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА.
- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ НЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАРЫГ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАГҮЙ БӨГӨӨД УГ МЭДЭЭЛЛИЙГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ”-ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА.
- ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛООГҮЙ БОЛ ЕРӨНХИЙ ШААРДЛАГАД НИЙЦЭХГҮЙ ГЭЖ УЗНЭ.

**ТШЗ 17.1 Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”**

- Борлуулалтын орлогын хэмжээ: **2021, 2022, 2023 ОНЫ АЛЬ НЭГ ЖИЛД НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ХЭМЖЭЭ НЬ БАТЛАГДСАН ТӨСВИЙН 10 ХУВИАС БАГАГҮЙ БАЙХ.**
- Гэрээний үүргийн биелэлтийг хангах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **ТЕНДЕРТ САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ҮНИЙН ДҮНГИЙН 30%-ААС БАГАГҮЙ БАЙХ.**
  - *Байгууллагын дансны үлдээгдэл\* /Харилцагч банкны тодорхойлолт, тендер нээхээс 7 хоногийн өмнө харилцагч банкнаас авсан байх/*
  - *Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ируулнэ. Тухайн зээл нь судлагдсан байх шаардлагатай. Тухайн тендерийн ажилтай холбоотой ямар нэгэн нөхцөл шаардлага тавихгүйгээр олгох зээлийг үнэлгээнд авч үзэх бөгөөд бусад тохиолдолд тус шаардлагыг хангаагүй гэж үзнэ.*
  - *Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд. /Хувь хүн эзэмшиж буй үнэт цаас, хадгаламж хамаарахгүй/*
- **Өр, төлбөртэй холбогдох шаардлага: “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН 4.1.5-Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БҮХИЙ “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГҮЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО. (“ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ [WWW.SAINSCORE.MN](http://WWW.SAINSCORE.MN), [WWW.BURENSCORE.MN](http://WWW.BURENSCORE.MN) ХАЯГААР ХАНДАН АВНА.**
- **Бусад шаардлага: СҮҮЛИЙН 3 ЖИЛ БУЮУ 2021, 2022, 2023 ОНУУДЫИН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛНЭ.**

**ТШЗ 17.2 Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:**

- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН МЭДЭЭЛЛИЙГ САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН [WWW.E-BALANCE.MOF.GOV.MN](http://WWW.E-BALANCE.MOF.GOV.MN) МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ДЭХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАНА.**

- ТҮРГЭН ХӨРВӨХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НИЙТ ДҮНГ ДАРААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН АЛЬ НЭГЭЭР ЭСВЭЛ НИЙЛБЭРЭЭР ТОДОРХОЙЛНО. ҮҮНД:
  - Тэндерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл;
  - Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт;
  - Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.
- ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА 2021, 2022, 2023 ОН;
- ХАРИЛЦАГЧ БАНКНЫ МЭДЭГДЭЛ;
- “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН 4.1.5-Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БҮХИЙ “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ”-ЫГ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГҮЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.
- СҮҮЛИЙН ХОЁР ХҮРТЭЛ ЖИЛИЙН ХУГАЦААНД ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ХУУЛИЙН ДАГУУ ГАРГАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН;
- СҮҮЛИЙН ХОЁР ХҮРТЭЛ ЖИЛИЙН ХУГАЦААНД ОРОЛЦОГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛСЭН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН МЭДЭЭЛЭЛ.
- САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙЛГЭХ ҮҮРЭГТЭЙ ОРОЛЦОГЧИЙН ХУВЬД САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНЭЛТ

#### ТШЗ 18.1

Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”

Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”

№	Албан тушаал	Ажилтны тоо	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Үндсэн /Гэрээт/	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага
1	Ерөнхий инженер	1	Ойн инженер, Ой зүйч, Ойн аж ахуйн инженер	Үндсэн	3 жилээс дээш
2	Ойжуулагч	1	Ойн аж ахуйн инженер ойн техникч, ойжуулагч	Гэрээт	3 жилээс дээш
3	Жолооч	2	Мэргэшсэн	Гэрээт	3 жилээс дээш
4	Түр ажилтан	20	-	Гэрээт	-

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН САНАЛ БОЛГОСОН НИЙТ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТӨЛСӨН БОЛОХЫГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАЖ ҮЗНЭ. ХЭРЭВ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БОЛ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕР ГЭЖ ҮЗНЭ.
- ТАТМЫИН ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙГ УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН

- АЖИЛТНУУДЫН ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛСАН ТАНИЛЦУУЛГА ИРҮҮЛНЭ.**
- **ҮНДСЭН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙГ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"-ЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАНА.** “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>
  - **ГАДААДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨН БОЛ ДИПЛОМОЫН ХУУЛБАРЫГ ОРЧУУЛАН ИРҮҮЛНЭ.**
  - **ЭРХ БУХИЙ БАЙГУУЛЛАГААС МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧДАД ОЛГОСОН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ, ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ГЭРЧИЛГЭЭГ ТУС ТУС НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭН ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛД ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.**
  - **ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БОЛОХЫГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"-ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. СҮҮЛИЙН 6 САР ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БАЙХ ШААРДЛАГАТАЙ. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНУУДЫН БИЧИГ БАРИМТЫГ ДУТУУ ИРҮҮЛЭХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ДЭЭР ДУРДСАН ХУГАЦААНД ТӨЛӨГДӨӨГҮЙ ТОХИОЛДОЛД УГ ТЕНДЕРЕЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.**

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардана”**

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Тоо хэмжээ	Хүчин чадал	Өөрийн / Түрээс
1	Трактор, дагалдах агрегатын хамт	2	80-аас дээш морины хүчтэй, 70 см хүртэл хагалах өгөгдөл анжис	Түрээс
2	Нүх ухагч	20	-	Өөрийн
3	Ачааны автомашин	1	5 тонн-оос дээш даацтай	Түрээс
4	Хүн тээврийн автомашин	1	8-10 хүн нэгэн зэрэг тээвэрлэх боломжтой	Түрээс

**ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМУУДЫН ЖАГСААЛТЫГ В БҮЛГИЙН МАЯГТ-3 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛНЭ. ТҮРЭЭССЭЭР ХЭРЭГЛЭХ БОЛ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ НОТАРИАТААР БАТЛУУЛЖ, ТҮРЭССИЙН ГЭРЭЭГ ХАВСАРГАНА. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖИЙН ХУВЬД ФОТО ЗУРГИЙГ ИРҮҮЛНЭ.**

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: **“Шаардана”**

**СҮҮЛИЙН З ЖИЛ БЮЮУ 2021, 2022, 2023 ОНУУДЫН АЛЬ НЭГ ЖИЛД ДООД ТАЛ НЬ НЭГ УДАА ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАСАН БАЙНА. ЭНЭ ШАЛГУУРЫГ ДООР ДУРДСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭР ХЯНАН ҮЗНЭ. /Ижил төстэй ажил гэдэгт байгалийн сэргэн ургалтад туслах, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн, төрөл бүрийн хамгаалалтын ойн зурvas байгуулсан, үр түүх байнгын болон түр талбай**

тусгаарлах арчлах, татмын ойжуулалт, булаг хөв цөөрмийг эргийг хамгаалах зурvas байгуулсан ажил гүйцэтгэж байсан туршлагыг голлон авч үзнэ./ **ҮҮНД:**

- **БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 10 ХУВИАС БАГАГҮЙ ҮНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ.**
- **ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГ ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ТУХАЙН БАГЦАД ЗААГДСАН АЖЛЫН НИЙТ ТАЛБАЙН ХЭМЖЭЭНИЙ 10 БОЛОН ТҮҮНЭС ДЭЭШ ХУВЬ БУХИЙ ТАЛБАЙД ДҮЙЦЭХҮЙЦ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ.**
- **ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭ, АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ЗАХИАЛАГЧИЙН ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ.**

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:  
**“Шаардана”**

- **ТЕНДЕРТ САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН 30-ААС ДЭЭШ ХУВЬ НЬ ОДОО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН ДУУСААГҮЙ АЖИЛД ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАНА.**

№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг, төг	Дууссан, дуусах хугацаа	Ажиллаж буй боловсон хүчний нэр, хугацаа
1					
2					

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: **“Шаардана”**

- **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,**
- **ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД БҮРЭН ХАРИУЦАН, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭН, АЖИЛЛАХ ТАЛААР БАТАЛСАН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ,**
- **ЗАХИАЛАГЧ ХАРИЛЦАГЧ БАНК, НИЙГМИЙН ДААТГАЛ, ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГУУДААС ТОДОРХОЙЛОЛТ ХҮСЭХЭД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛГҮЙ ТУХАЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН АЛБАН МЭДЭГДЭЛ,**
- **АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ЧАНАРЫН ЗӨРЧИЛ, ГОЛОГДОЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ТҮҮНИЙГ ЗАСАХ, ЗАЛРУУЛАХ ТУХАЙ ШААРДЛАГА ӨГӨХӨД ҮЛ МАРГАЛДАХ ЖУРМААР БИЕЛҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,**
- **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ДАГУУ ТООЦСОН ТӨСӨВ ИРҮҮЛНЭ. УГ ТӨСӨВТ ХОЛБОГДОХ ТАТВАР ХУРААМЖ, ДААТГАЛЫГ БҮРЭН ХАМРУУЛСАН БАЙНА.**
- **ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ, ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ БАТАЛГААЖУУЛЖ ИРҮҮЛЭХ,**
- **САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ БАЙГУУЛСАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, НОТАРИАТААР БАТАЛГААЖУУЛАН ИРҮҮЛЭХ,**
- **ТЕНДЕРТ ШАЛГАРСАН ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ЗАХИАЛАГЧААС ТОГТООСОН ҮЕ ШАТНЫ ХУВААРТЬ ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ ЧАНАРЫН Өндөр**
- **ТҮВШИНД ТУХАЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭН ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭН Өгөх БАТАЛГААГ БИЧГЭЭР ГАРГАЖ ИРҮҮЛНЭ.**
- **СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН АЛЬ НЭГ ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР**

**ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХИЙСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ. ГЭРЭЭ БОЛОН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТЫН ХУУЛБАРЫГ ХАВСАРГАНА. ДУУСААГҮЙ ГЭРЭЭНИЙ ХУВЬД ТАЙЛБАР ХИЙСЭН БАЙНА.**

- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ӨӨРӨӨ ҮЙЛДВЭРЛЭЭГҮЙ ТАРЬЦ, СУУЛГАЦЫГ АШИГЛАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ САНАЛ ИРҮҮЛЖ БУЙ ТОХИОЛДОЛД ТАРЬЦ, СУУЛГАЦ НИЙЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БОЛОХЫГ НОТЛОХ НИЙЛҮҮЛЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ИРҮҮЛНЭ.**
- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ОЛОН БАГЦАД ТЕНДЕР ИРҮҮЛЭХ БОЛОН ӨӨР ИЖИЛ ТӨРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БОЛ ЗӨВХӨН ТУХАЙН БАГЦАД АЖИЛЛУУЛАХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫГ САНАЛ БОЛГОСОН ТЕНДЕР ИРҮҮЛНЭ. (ХЭРЭВ ЗАХИАЛАГЧИЙН ЗАРЛАСАН БУСАД ТЕНДЕРҮҮДЭД САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАН ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.)**

**ТШЗ 18.2 Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:**

Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлнэ. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ҮНДСЭН АЖИЛТАН, ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ АЖИЛЛАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ СИСТЕМ ДЭХ V БҮЛЭГТ ЗААСАН МАЯГТААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ САНАЛ БОЛГОНО. ЦАХИМ СИСТЕМЭЭР САНАЛ БОЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД ХЯНАН ҮЗЭХГҮЙ. ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ХӨТӨЧ ЦЭСИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА ХЭСГЭЭС ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦАНА УУ.**
- **АЖИЛТНЫ СУРГУУЛЬ ТӨГССӨН ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАГҮЙ, ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ, СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАНА. (ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ /E-MONGOLIA/-Д АЖИЛТНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ДИПЛОМЫН МЭДЭЭЛЭЛ БАЙРШАН ЭСЭХИЙГ УРЬДЧИЛАН ШАЛГАХ ШААРДЛАГАТАЙГ АНХААРНА УУ.) ХЭРЭВ САНАЛ БОЛГОЖ БУЙ АЖИЛТАН НЬ ГАДААД УЛСАД СУРГУУЛЬ ТӨГССӨН БОЛ ДИПЛОМЫН ХУУЛБАРЫГ ОРЧУУЛГЫН ХАМТ ИРҮҮЛНЭ.**
- **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ҮНДСЭН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. БУСАД АЖИЛТНЫ ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭГ ЗӨВХӨН ТУХАЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗОРИУЛАН БАЙГУУЛСАН БАЙНА.**
- **МЭРГЭШСЭН, ЗӨВЛӨХ ЗЭРЭГТЭЙ АЖИЛТАН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛТНЫ ХУЧИН ТӨГӨЛДӨР МЭРГЭЖЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ ТЕНДЕРТ ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.**
- **НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 3.1.4-Т ЗААСАН НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫГ САНАЛ БОЛГОХ ТОХИОЛДОЛД МӨН ХУУЛИЙН 18.5.3-Т ЗААСАН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН БИЧГЭЭР ӨГСӨН ЗӨВШӨӨРЛИЙГ ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.**
- **ТУХАЙН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ДЭЭРХ САНАЛ БОЛГОСОН АЖИЛТНААС ӨӨР АЖИЛТНААР АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛСЭН ТОХИОЛДОЛД ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ БҮХИЙ ТЕНДЕР ГЭЖ ҮЗЭН ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД ХАМРУУЛАХ НӨХЦӨЛ БОЛОХЫГ АНХААРНА УУ.**

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН БОЛОН ТУРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ АШИГЛАХ МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЦАХИМ СИСТЕМ ДЭХ В БҮЛЭГТ ЗААСАН МАЯГТААР ЗААВАРЧИЛГААНЫ ДАГУУ САНАЛ БОЛГОНО. ЦАХИМ СИСТЕМЭЭР САНАЛ БОЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД ХЯНАН ҮЗЭХГҮЙ. ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ХӨТӨЧ ЦЭСИЙН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА ХЭСГЭЭС ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦАНА УУ.
- МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТУРЭЭСИЙН ГЭРЭЭ НЬ ИРГЭНИЙ ХУУЛИЙН 318 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦСЭН, МАШИН МЕХАНИЗМЫН УЛСЫН ДУГААР, АШИГЛАХ ХУГАЦДАА, ТУРЭЭСИЙН ТӨЛБӨР БУСАД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙ ТУСГАСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ.

Оролцгчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн 4, 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. Үүнд:

- ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГЭЭР ТООЦУУЛАХ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН ХУВЬД: АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭ, ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ, ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН ДҮГНЭЛТ, АКТЫГ ИРҮҮЛНЭ.
- ХҮЧИН ЧАДАЛ, ОЙЖУУЛСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭГЭЭР ТООЦУУЛАХ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГЫН ШААРДЛАГЫН ХУВЬД: АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭ, ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН ДҮГНЭЛТ, АКТЫГ ИРҮҮЛНЭ.

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:

- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ӨӨРИЙН БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ТУС ТУС ИРҮҮЛНЭ.
- ЗАХИАЛАГЧ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦ, АЖИЛТАН, МАШИН МЕХАНИЗМЫН ТАЛААР МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙГ САНГААС ХЯНАН ҮЗНЭ.

### ТШЗ 18.3

Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”

“ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫН 4.1.6 ДАХЬ ЗААЛТАД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА. ҮҮНД:

- ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ (МОД ҮРЖҮҮЛЭХ, ОЙЖУУЛАХ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ)

### ТШЗ 20.2

Оролцгчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ТОХИРУУЛАХГҮЙ”

### ТШЗ 24.1

Тендерийн баталгааны дун: **500,000.00 (таван зуун мянган төгрөг)**

Тендерийн баталгааг материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерийн баталгаа гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна. Захиалагч тендерийн баталгааг хуулийн 28.1.1-д зааснаар “хамгийн сайн тендер ирүүлсэн” оролцгчид гэрээ байгуулсны дараа цахим системээр хүчингүй болгоно. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн A/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион

байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын 2.3.3 дахь хэсэгт заасны дагуу цахим системээр дамжуулан тендерийн баталгааг ирүүлнэ

#### **Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ**

**ТШЗ 25.5** Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:

- **ТЕНДЕРТ ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ТОВЧОО;**
- **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУВААРЬ.**

**ТШЗ 26.1** Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь

Огноо: **2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр**

Цаг: **10 цаг 00 минут**

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### САНАМЖ

Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бух бараа, материал нь шинэ, ашиглалдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “Эсхүүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАННАА

2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН XIV ХОРОО, ТҮРГЭНИЙ  
ГОД БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН НЭРЭМЖИТ  
ТӨГӨЛ БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Үндэслэл	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2024 оны А/51 дугаар тушаалаар батлагдсан “Ойжуулалт хөтөлбөрийн 2024 онд үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрэмжит төгөл” байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
2	Гүйцэтгэх ажил	<p>“Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрэмжит төгөл” ажил нь доор дурдсан үе шаттай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➤ Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 14 дүгээр хороо, Түргэний голд 1.17 га талбайд төгөл байгуулах, цэцэрлэгжүүлэлтийн ажлын зураг, төсөв боловсруулах</li><li>➤ Төгөл байгуулах цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар мод тарих, арчлан ургуулах<ul style="list-style-type: none"><li>- Шинэс 150 ширхэг</li><li>- Гацуур 100 ширхэг</li><li>- Хус 100 ширхэг</li><li>- Монос 50 ширхэг</li><li>- Өрөл 50 ширхэг</li><li>- Тошлог 100 ширхэг</li><li>- Сарнай 50 ширхэг</li></ul></li></ul>
3	Төсөвт өртөг	100.000.000.00 (нэг зуун сая) төгрөг
4	Ажлын хэмжээ	600 ширхэг мод, сөөгийн суулгац суулгах

		Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, "Түргэний цэцэрлэг", талбайн байршил																																																												
5	Байршлын цэгүүд	<table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>X</th><th>Y</th></tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>106°42'36.77"E</td><td>47°46'20.41"N</td></tr> <tr><td>2</td><td>106°42'38.33"E</td><td>47°46'21.84"N</td></tr> <tr><td>3</td><td>106°42'37.76"E</td><td>47°46'22.17"N</td></tr> <tr><td>4</td><td>106°42'35.44"E</td><td>47°46'22.87"N</td></tr> <tr><td>5</td><td>106°42'35.85"E</td><td>47°46'23.88"N</td></tr> <tr><td>6</td><td>106°42'30.87"E</td><td>47°46'24.85"N</td></tr> <tr><td>7</td><td>106°42'29.51"E</td><td>47°46'23.21"N</td></tr> </tbody> </table>	№	X	Y	1	106°42'36.77"E	47°46'20.41"N	2	106°42'38.33"E	47°46'21.84"N	3	106°42'37.76"E	47°46'22.17"N	4	106°42'35.44"E	47°46'22.87"N	5	106°42'35.85"E	47°46'23.88"N	6	106°42'30.87"E	47°46'24.85"N	7	106°42'29.51"E	47°46'23.21"N																																				
№	X	Y																																																												
1	106°42'36.77"E	47°46'20.41"N																																																												
2	106°42'38.33"E	47°46'21.84"N																																																												
3	106°42'37.76"E	47°46'22.17"N																																																												
4	106°42'35.44"E	47°46'22.87"N																																																												
5	106°42'35.85"E	47°46'23.88"N																																																												
6	106°42'30.87"E	47°46'24.85"N																																																												
7	106°42'29.51"E	47°46'23.21"N																																																												
6	Техникийн шаардлага	<p>Монгол оронд ургадаг, нутагшсан мод, сөөгийн зүйл сонгож, доор дурдсан стандартуудыг мөрдөнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Сөөгний суулгац MNS 6255:2011</li> <li>➤ Сөөгэнцөрийн суулгац MNS 6256:2011</li> <li>➤ Шилмүүст модны суулгац MNS 6139:2010</li> <li>➤ Навчтэй модны суулгац MNS 6141-1:2010</li> <li>➤ Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах Ерөнхий шаардлага MNS 6258-1:2011</li> <li>➤ Мод, сөөгний суулгац арчлах MNS 6258-2:2011</li> <li>➤ Холимог хөрс бэлтгэх</li> <li>➤ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа MNS 4969:2000</li> <li>➤ Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага MNS 5891:2008</li> </ul>																																																												
7	Модны төрөл, тоо хэмжээ, стандартын шаардлага	<table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Модны төрөл</th><th>Тоо хэмжээ</th><th>Өндөр, метр</th><th>Цээжний диатемр, см</th><th>Зэрэг</th></tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>Шинэс</td><td>150</td><td>1</td><td></td><td>I</td></tr> <tr><td>2</td><td>Гацуур</td><td>100</td><td>1</td><td></td><td>I</td></tr> <tr><td>3</td><td>Хус</td><td>100</td><td>1</td><td></td><td>I</td></tr> <tr><td>4</td><td>Монос</td><td>50</td><td>1</td><td></td><td>I</td></tr> <tr><td>5</td><td>Өрөл</td><td>50</td><td>1</td><td></td><td>I</td></tr> <tr><td>6</td><td>Тошлог</td><td>100</td><td>0.6</td><td></td><td>I</td></tr> <tr><td>7</td><td>Сарнай</td><td>50</td><td>0.6</td><td></td><td>I</td></tr> <tr><td>8</td><td>Бусад</td><td>....</td><td></td><td></td><td>I</td></tr> <tr> <td colspan="6">Дүн</td></tr> </tbody> </table> <p>Бойжуулах талбайд шилжүүлэн 2-3 жил ургуулсан мод, сөөг суулгаж, Зжилийн турш арчлан хамгаална.</p>	№	Модны төрөл	Тоо хэмжээ	Өндөр, метр	Цээжний диатемр, см	Зэрэг	1	Шинэс	150	1		I	2	Гацуур	100	1		I	3	Хус	100	1		I	4	Монос	50	1		I	5	Өрөл	50	1		I	6	Тошлог	100	0.6		I	7	Сарнай	50	0.6		I	8	Бусад	....			I	Дүн					
№	Модны төрөл	Тоо хэмжээ	Өндөр, метр	Цээжний диатемр, см	Зэрэг																																																									
1	Шинэс	150	1		I																																																									
2	Гацуур	100	1		I																																																									
3	Хус	100	1		I																																																									
4	Монос	50	1		I																																																									
5	Өрөл	50	1		I																																																									
6	Тошлог	100	0.6		I																																																									
7	Сарнай	50	0.6		I																																																									
8	Бусад	....			I																																																									
Дүн																																																														
8	Гүйцэтгэх хугацаа	Шалгарч гэрээ байгуулсан хугацаанаас хойш 2024 оны 10 дугаар сарын 25 хүртэл.																																																												
9	Ажлын хамрах хүрээ	<p>Дараах ажилбаруудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бэлтгэл ажил</li> <li>2. Мод, сөөг суулгах</li> <li>3. Усалгааны систем суурилуулах</li> </ol>																																																												

		<p>4. Нөхөн тарилт хийх /шаардлагатай бол/      5. Зөрчил гомдол арилгах      6. Ажлын болон санхүүгийн гүйцэтгэлийн тайлан гаргах      7. Тайлан боловсруулах      8. Ажлыг дүгнэх, акт бүрдүүлэх      9. Орон нутагт ажлыг хүлээлгэн өгөх</p>
9	Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд	<p>1. Бэлтгэл ажил:</p> <ul style="list-style-type: none"> <li>Цэг тавих, улаан шугам татах</li> <li>Мод, сөөгийн нүх ухаж бэлтгэх</li> <li>Холимог хөрс бэлтгэх /тарилтад ашиглах мод, сөөгийг суулгах хар шороо, шаваргүй, шигшсэн элс, хөх бууц, 1 жилээс дээш хугацаанд өнжсөн үртэс зэргийг хольж ашиглаж болно/</li> <li>Мод, сөөгийн стандарт суулгац бэлтгэх, түр хадгалах /суулгацын нахиа, мөчир хугарч гэмтээгүй, модны суулгац гол үндэс тасраагүй, сөөгийн үндэсний системийн салаалалт сайн, хаталт, цууралтгүй, өвчин хортонд өртөөгүй байна/</li> <li>Төрийн захиргааны төв байгууллагын нэрэмжит төгөл байгуулсан талбайд мэдээллийн самбар байрлуулна. Самбарын нийт өндөр 3 метрээс багагүй, төмөр хийцтэй байх бөгөөд самбарын хэмжээ 1x1 метрээс багагүй байна. Самбарын хөлийн бетон зуурмагаар бэхэлсэн байна. Самбарын мэдээлэлд ойжуулалт хийсэн талбайн зураг, захиалагч болон гүйцэтгэгчийн тухай мэдээлэл, талбайн хэмжээ, тарьсан модны төрөл, тоо ширхэг зэрэг мэдээллүүдийг заавал оруулсан байна.</li> </ul>
10		<p>2. Мод, сөөг суулгах.</p> <ul style="list-style-type: none"> <li>Мод сөөгийн суулгацыг техникийн шаардлагын стандарт мөрдөж суулгана.</li> <li>Орон нутгаас өгсөн цэгийн газарт, батлагдсан зургийн дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.</li> <li>Ажлыг санхүүжилтийн гэрээ батлагдсан өдрөөс эхлэн гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилтыг ургамал тайван байдалд орсон үед эсвэл тусгайлан саванд суулгасан суулгацаар ажил хүлээлцэхээс өмнө гүйцэтгэсэн байна.</li> </ul> <p>3.Усалгааны систем, нөөцийн сав суурилуулах</p> <ul style="list-style-type: none"> <li>Мод, сөөгийг суулгасан 1.17 га талбайд тарьсан мөрийн дагуу мод бүрт дуслын усалгааны систем байршуулах,</li> <li>1 тн хэмжээтэй нөөцийн сав 3 ширхэгийг байршуулж дуслын усалгааг хийх шаардлагатай усны насос байршуулах</li> </ul>
11		<p>4. Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх.</p> <ul style="list-style-type: none"> <li>Захиалагчаас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Ажлын явцын хяналтыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэг, захиалагчаас томилсон хөндлөнгийн ажлын хэсэг тус тус хийж гүйцэтгэнэ.</li> <li>Санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлыг засаг захиргааны нэгжийн холбогдох байгууллагад акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ.</li> <li>Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн суулгасан суулгацын амьдралт 90-100% байвал уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна.</li> <li>Амьдралтын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан 7 дугаар хавсралт “Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох” ажлыг хүлээж авсан актын дагуу хүлээн авна.</li> <li>Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн засаг захиргааны нэгжийн Байгаль орчны газартай хамтран ажиллана.</li> </ul>
12		<p>5. Зөрчил, гологдол арилгах.</p> <ul style="list-style-type: none"> <li>Суулгасан мод, сөөгийн ургалтын хувь бага бол гүйцэтгэгч өөрийн зардлаар шаардлагатай нөхөн тарилтын ажлыг хийж, актаар хүлээлгэн өгнө.</li> <li>Суулгасан мод, сөөг 75&gt; хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.</li> <li>Суулгасан мод, сөөг 30&gt; хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.</li> </ul>
13		<p>6. Тайлан боловсруулах.</p> <p>Ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд</p> <p>а/ “Ажил гүйцэтгэсэн тайлан”;</p> <p>б/ Цэцэрлэгжүүлэлтийн зураг 1:1000 масштабтай зураг</p> <p>в/ Техникийн шаардлага болон ажил гүйцэтгэх графикийн үе шатны дагуу хийгдсэн ажил тус бүрийн хэмжээ, бүртгэл, тайлбар тодорхой бичигдсэн, хавсралт фото зураг</p> <p>г/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу орон нутгийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.</p> <p>д/ Талбайн мод тооллого явуулсан хүснэгт</p> <p>а. “Ажил гүйцэтгэсэн тайлан”-д:</p>

		<p>Гүйцэтгэсэн ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, мод суулгах ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана.</p> <p>б. “Ажлын зураг”-т модны төрөл, нас, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг тохижилтийн зургаар гүйцэтгэж оруулна.</p> <p>в. Техникийн шаардлага болон ажил гүйцэтгэх графикийн үе шатны дагуу хийгдсэн ажил тус бүрийн хэмжээ, бүртгэл, тайлбар тодорхой бичигдсэн, хавсралт фото зураг нь нягтрал сайн мэргэжлийн төхөөрөмжөөр авсан, он сар бичигдсэн зураг оруулна.</p> <p>г. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланда хавсаргана.</p> <p>д. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан 7 дугаар хавсралт “Хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох” ажлыг хүлээж актын маягт, тарьсан модны тооллогын хүснэгт хөтөлсөн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланда зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.</li> </ul>
14		<p>7. Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гүйцэтгэсэн ажлын тайланг Ойн газарт хоёр хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарыт тусгасан болно. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ.</li> </ul> <p>8. Дараа жилийн арчилгаа, хамгаалалт</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гүйцэтгэсэн ажлыг орон нутаг хүлээн авч, ажлын хэмжээг тодорхой тогтоож, үнэлэн арчилгааны зардлыг дараа жилийн төсөвт тусган мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.</li> <li>• Ажлын хэмжээнд: Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, хашаа хамгаалалтыг сэргээх, усалгаа хийх, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээ, тэдгээрт шаардлагатай материалын зардлууд тусгагдана.</li> </ul>

Даалгаврыг хянасан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга

Б.Ганзориг

Даалгавар боловсруулсан:

Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн Ногоон  
байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн  
менежментийн асуудал хариуцсан  
ахлах мэргэжилтэн:

А.Оюунгэрэл

Байршил



## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөж шаардлагатай бүх маягтыг тусгана.

### Агуулга

Маягт 1: Тендер илгээх маягт .....	28
Маягт 2: Ижил төстэй ажил нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....	29
Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....	29
Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл.....	29
Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт.....	30

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон ажил нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй ажил нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

**Маягт 6: Тендерийн баталгаа**

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол өөрийн нэрийн өмнөөс захиалагчтай харилцах, мэдэгдэл хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан эрх бүхий этгээдийг заана уу.]

[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

**Маягт 7: Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл**

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

**Маягт 8: Тендерт санал болгож байгаа хүний нөөцийн мэдээлэл**

Машин механизмын тооног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Г“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

#### Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

1.1.1.“Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.2.“Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.3.“Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4.“Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.5.“Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6.“Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7.“Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.8.“Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;

1.1.9.“Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;

1.1.10.“Гомдолын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11.“Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

#### Тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

		1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
		1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
		<b>ХОЁР. ЗАХИАЛАГЧ</b>
<b>Захиалагчийн нийтлэг үүрэг</b>		2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
<b>Захиалагчийн төлөөлөгч</b>		2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
<b>Талбайд нэвтрэх зөвшөөрөл</b>		2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
<b>Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг</b>		2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
<b>Гүйцэтгэгчийн төлөөлөгч</b>		2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
		2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
		2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
		2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.
		<b>ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ</b>
		3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцуулэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
		3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
		3.3. Ажил гүйцэтгэхэд шаардлагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
		3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгчхариуцна.
		3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 10 (арав) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
		3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
		3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
		3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбарыар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
		3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

<b>Техникийн ажлын талбайн өгөгдөл</b>	3.11.Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
<b>Ажлын талбайн харул хамгаалалт</b>	3.12.Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна. 3.13.Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>Хог, хаягдал ба нөхөн сэргээлт</b>	3.14.Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана. 3.15.Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалыудыг зохих ёсоор хадгалж, устгана. 3.16.ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
<b>Археологийн болон бусад олдвор</b>	3.17.Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө. 3.18.Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна. 3.19.Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
<b>Аюулгүй байдал</b>	3.20.Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана. 3.21.Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална. 3.22.Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. 3.23.Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна. 3.24.Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна. 3.25.Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

<b>Ажил эхлэх</b>	4.1.Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ. 4.2.Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ. 4.3.Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс
	33

<p><b>Хугацаа сунгах</b></p>	<p>дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.</p> <p>4.4.Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.</p> <p>4.5.Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> <li>4.5.1.ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;</li> <li>4.5.2.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;</li> <li>4.5.3.Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;</li> <li>4.5.4.Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.</li> </ul> <p>4.6.Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7.ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8.Захиалагч ГЕН-ийн 4.5.-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9.Гүйцэтгэгч ажлын явцын тайлант ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10.Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрал, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p>
<p><b>Ажлын явцын тайлан</b></p>	<p><b>ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ</b></p>
<p><b>Гэрээний үнэ</b></p>	<p>5.1.Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2.Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3.ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p>
<p><b>Урьдчилгаа төлбөр</b></p>	<p>5.4.Төндөр шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5.Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p> <p>5.6.Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7.Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p>
<p><b>Төлбөрийн нөхцөл</b></p>	<p>34</p>

5.8.Гүйцэтгэчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

5.9.Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

5.10.Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

5.11.Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

**Урьдчилгаа  
төлбөрийн баталгаа**

6.1.ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.

6.2.Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

6.3.Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

6.3.1.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

6.3.2.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

6.3.3.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

6.4.Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

6.5.ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

6.6.Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.

6.7.Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.

6.8.Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.

6.9.ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

6.10.Баталгаат хугацаанд ажилд аливаа догоилдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

6.11.ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол догоилдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.

		6.12.ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
<b>Баталгаат хугацаа</b>		6.13.Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
<b>Бусдад учруулсан хохирлыг арилгах</b>		6.14.Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
		<b>ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ</b>
<b>Захиалагчийн хүлээх эрсдэл</b>		7.1.Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
<b>Даатгал</b>		7.2.Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
		7.3.Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
		7.3.1.ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
		7.3.2.гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
		7.3.3.Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
		7.3.4.Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
		7.4.Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
<b>Доголдлыг илрүүлэх, арилгах</b>		7.5.Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
		7.6.Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
		7.7.Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
		7.8.Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
		7.9.Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
		<b>НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ</b>
		8.1.Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
		8.2.Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
		8.3.Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол

		илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
		8.4.Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
		8.5.Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
		8.6.Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
		8.7.Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
		8.8.Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
<b>Далд доголдол</b>		8.9.Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
<b>Зураг доголдол</b>	<b>төслийн</b>	8.10.Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
		8.11.Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
		<b>ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ</b>
<b>Захиалагч цуцлах</b>	<b>гэрээг</b>	9.1.Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: 9.1.1.Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон; 9.1.2.Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараягүй; 9.1.3.Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн; 9.1.4.Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгалын гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон; 9.1.5.ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн; 9.1.6.Гүйцэтгэгч нийт ажлын 10 (арав)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн; 9.1.7.Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон. 9.1.8.Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
<b>Гүйцэтгэгч цуцлах</b>	<b>гэрээг</b>	9.2.Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно. 9.3.Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: 9.3.1.Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;

<p><b>Гэрээг цуцлах журам</b></p>	<p>9.3.2.ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.3.3.Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.</p>
<p><b>Гэрээг цуцалсны дараах төлбөр</b></p>	<p>9.4.Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>9.5.Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> <p>9.6.Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>9.7.Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.</p> <p>9.8.ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.</p> <p>9.9.ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:</p> <ul style="list-style-type: none"> <li>9.9.1.Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;</li> <li>9.9.2.Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;</li> <li>9.9.3.Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;</li> <li>9.9.4.Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;</li> <li>9.9.5.Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.</li> </ul>
<p><b>АРАВ. БУСАД ЗААЛТ</b></p> <p><b>Мэдэгдэл</b></p>	<p>10.1.Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.</p> <p>10.2.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>10.3.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>10.4.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> <li>10.4.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</li> </ul>

<b>Төлөөлөгч өөрчлөгдөх</b>	<p>10.4.2.Биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>10.5.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.6.ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>10.7.Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>10.8.Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.</p> <p>10.9.Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.10.Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.</p> <p>10.11.Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.</p> <p>10.12.Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.13.Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.</p> <p>10.14.Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-д заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15.Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>10.16.Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17.Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19.Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p>
<b>Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл</b>	
<b>Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал</b>	

<b>Оюуны өмчийн эрх зөрчих</b>	10.20.Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
<b>Алданги</b>	10.21.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
	10.22.Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
	10.23.Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
	10.24.Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
<b>Маргаан шийдвэрлэх</b>	10.25.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
	10.26.Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 4.1.** Ажил эхлэх хугацаа: ***Гэрээ байгуулагдсанаас хойш***
- ГЕН 4.2.** Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: ***Гэрээ байгуулснаас хойш 5 хоногын дотор***
- ГЕН 4.9.** Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: ***2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор***
- ГЕН 5.2.** Үнийн тохироулга: ***“Хийхгүй”***
- ГЕН 5.4.** Урьдчилгаа төлбөр олгох эсэх: ***“Үгүй”***
- ГЕН 5.5.** Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: ***“айхгүй”***
- ГЕН 5.6.** Төлбөр төлөх хугацаа: ***“Ажил гүйцэтгэлээр тооцно”***
- ГЕН 6.1.** Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: ***“байхгүй”***
- ГЕН 6.8.** Чанарын баталгаа:
- Чанарын баталгаа шаардах эсэх: ***“Шаардана”***
- Чанарын баталгааны хэмжээ: ***Гэрээний үнийн дүнгийн 5 хувь***
- ГЕН 6.14.** Баталгаат хугацаа: ***2 жил***
- ГЕН 7.5.** Даатгал:
- “Холбогдох хуулийн дагуу гарах даатгалын зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна”***
- ГЕН 10.21.** Захиалагчийн төлөх алдангийн хувь:  
Алдангийн хувь: ***Хоног тутамд 0 хувь***
- ГЕН 10.22.** Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:  
Алдангийн хувь: ***Хоног тутамд 0.5 хувь***

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
- 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
- 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
- 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
- 3.7. Техникийн тодорхойлолт;
- 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө.  
Үүнд:

### 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

### 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_  
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_  
ТАМГА

